

ҮСХ-ны даргын 2015 оны 5
дугаар сарын 27-ны
өдрийн А/70 тоот
тушаалын хавсралт



ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

**ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2015 ОНЫ ЗАВСРЫН ТООЛЛОГЫН ҮЗЭЛ
БАРИМТЛАЛ**

2015 он

АГУУЛГА

1. Нийтлэг үндэслэл	2
2. Зорилго, зорилт	2
3. Завсрын тооллогыг явуулах арга	3
4. Тооллогын тов, хамрах хүрээ, тооллогын нэгж	3
5. Удирдлага, зохион байгуулалт	4
6. Мэдээллийн үзүүлэлт.....	5
7. Ангилал, код	6
8. Технологи.....	7
9. Сурталчилгаа.....	8
10. Туршилт	9
11. Мэдээлэл цуглуулалт, хяналт, мониторинг	9
12. Хяналтын тооллого	9
12.1 Түүврийн хүрээ, хэмжээ.....	10
12.2 Баримтлах зарчим	10
12.3 Мэдээллийг боловсруулах	10
12.4 Үнэлгээний үзүүлэлтийн аргачлал.....	10
13. Боловсруулалт, үр дүнгийн хүснэгт.....	11
14. Тархаах хэвлэн нийтлэх.....	11
15. Тооллогын үйл ажиллагааг баримтжуулах.....	11
16. Бусад асуудал	11
16.1 Нууцлал, аюулгүй байдал	11
16.2 Төсвийн бүтэц	12
16.3 Төлөвлөлт.....	13
ХАВСРАЛТ	14
Улсын хороо, аймаг, нийслэлийн комиссын бүрэлдэхүүн.....	14
Үр дүнгийн хүснэгтийн жагсаалт	16
Хүн ам, орон сууцны 2015 оны завсрын тооллогын үйл ажиллагааны дэлгэрэнгүй төлөвлөгөө	22

1. Нийтлэг үндэслэл

Монгол улс хүн ам, орон сууцны 10 дахь тооллогыг 2010 онд НҮБ-аас боловсруулсан “Хүн ам, орон сууцны тооллого явуулахад дагаж мөрдөх үндсэн зарчим, арга зүйн зөвлөмж”-ийг үндэслэн олон улсын нийтлэг жишгийн дагуу зохион байгуулсан билээ.

Энэ тооллогоос хойш төр засгийн хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт, нийгэм, эдийн засгийн цаашдын чиг хандлагыг тодохойлоход хүн амын талаарх илүү өргөн мэдээлэл бий болгох шаардлага тулгарч байна. Энэхүү хэрэгцээг хангах үүднээс Хүн ам, орон сууцны 2015 оны завсрын тооллого нь суурь мэдээлэл болох юм.

Монгол Улсын хүн амын байршлыг бүрэн зөв тодорхойлох, гадаадад зорчиж буй иргэдийнхээ эрхийг хамгаалах, манай улсад урт болон богино хугацаагаар оршин суухаар ирж буй гадаадын иргэдийн бүртгэл, хүн ам, өрхийн болон гадаад шилжих хөдөлгөөний сангуудын хоорондын уялдааг сайжруулах, мэдээллийн сангийн чанарыг дээшлүүлж, ашиглалт, хэрэглээг нэмэгдүүлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгоход завсрын тооллогын ач холбогдол оршино. Түүнчлэн хүн ам, орон сууцны 2020 оны тооллогыг явуулах бэлтгэл нөхцөл болно.

Монгол Улсын “Статистикийн тухай” хуулийн 7.1-ийн а-д “хүн ам, орон сууцны улсын ээлжит тооллогыг 10 жил тутам, завсрын тооллогыг 5 жил тутам”, “Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “Завсрын тооллогын тов, үргэлжлэх хугацаа, хамрах хүрээг Үндэсний статистикийн хороо тухай бүр тогтооно” гэж тус тус заасны дагуу Үндэсний статистикийн хороо “Хүн ам, орон сууцны завсрын тооллого”-ыг 2015 онд зохион байгуулж явуулахаар төлөвлөж, бэлтгэл ажлаа ханган ажиллаж байна.

2. Зорилго, зорилт

Хүн ам, орон сууцны 2015 оны завсрын тооллогын үндсэн зорилго нь Монгол Улсын “Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хуулийн 9.2 дахь заалтын дагуу “ээлжит тооллогын мэдээллийг тодотгох, шинэчлэн өргөжүүлэх зорилготой хүн ам зүй, эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн дэлгэрэнгүй судалгаа явуулахад оршино. Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Хүн ам, өрхийн мэдээллийн сан (цаашид ХАӨМС гэх)-гийн иж, бүрдэлтийг хангаж, чанартай хийж, ашиглалт, хэрэглээг нэмэгдүүлэх
- ХАӨМС-г төрийн захиргааны болон салбарын төв байгууллагуудын холбогдох сангуудтай уялдуулж, мэдээллийн нэгдсэн сүлжээ бүрдүүлэх
- Ээлжит тооллогын зарим мэдээллийг тодотгох, шинэчлэн өргөжүүлэх
- Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогыг явуулах суурь нөхцөлийг хангах
- Өрхөд суурилсан судалгааны түүврийн хүрээ бүрдүүлэх

Эдгээр зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд завсрын тооллогоор дараах асуудлуудыг шийдвэрлэнэ. Үүнд:

- ХАӨМС-г бүрэн бүрдүүлж, түүний ашиглалт, хэрэглээг нэмэгдүүлэх
- Тооллогын удирдлага, зохион байгуулалтыг бий болгох
- Завсрын тооллогын төсвийг нарийвчлан тооцож батлуулах, шаардлагатай нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох
- Тооллогын ажилтнуудын сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах
- ХАӨМС-г төрийн байгууллагуудын мэдээллийн сангуудтай уялдуулах, шаардлагатай сангуудыг бий болгох, нэгдсэн удирдлагаар хангах
- ХАӨМС-гийн баяжилтыг үе шаттайгаар хийж, бүрэн дуусгах
- ХАӨМС-гийн мэдээллийн баяжуулалтад дэвшилтэт технологи, програм хангамж ашиглах
- Газар зүйн мэдээллийн нэгдсэн санг баяжуулж, өрхийн байршлыг шинэчлэх
- Завсрын тооллогын үр дүнг гаргах үзүүлэлт, хүснэгтийг боловсруулж, тэдгээрийн хоорондын уялдааг нягтлах, бодлогын даалгавар боловсруулж, туршиж бэлэн болгох

3. Завсрын тооллогыг явуулах арга

Завсрын тооллогыг Монгол Улсын “Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хуулийн 4.1.2 дахь заалтын “хүн амын регистрийн бүртгэлд суурилсан бүртгэлийн арга”-ыг үндэслэн зохион байгуулж явуулна.

4. Тооллогын тов, хамрах хүрээ, тооллогын нэгж

Завсрын тооллогын товыг 2015 оны 12-р сарын ... өдрөөс ... өдөрт шилжих шөнийн тэг (00.00) цагаар тогтоож, үр дүнг ХАӨМС-г холбогдох сангуудтай уялдуулж гаргана.

Хамрах хүрээ. Монгол Улсын “Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хуулийн 10-р зүйлд заасны дагуу дараах хувь хүн, орон сууцыг тооллогод хамруулна.

10.1. Хүн амын тооллогод дараах хувь хүнийг хамруулна. Үүнд:

10.1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа Монгол Улсын иргэн

10.1.2. Монгол Улсын нутаг дэвсгэрт 183 хоногоос дээш хугацаатай оршин сууж байгаа болон оршин суухаар эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан гадаадын харьяат иргэн, харьяалалгүй хүн

10.1.3. гадаадад оршин суугаа Монгол Улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагад ажиллаж байгаа Монгол Улсын иргэн, түүний гэр бүл

10.1.4. гадаадад ажиллаж, суралцаж байгаа болон хувийн хэргээр оршин суугаа Монгол Улсын иргэн орно.

10.2. Орон сууцны тооллогод дараах байр, орон сууцыг хамруулна. Үүнд:

10.2.1. сууцны тусдаа байшин

10.2.2.нийтийн зориулалттай орон сууцны барилгын доторх сууц

10.2.3.бүх төрлийн гэр

10.2.4.нийтийн байр

10.2.5.сууцны бус зориулалттай бусад байр, талбай орно.

5. Удирдлага, зохион байгуулалт

Хороо. Үндэсний статистикийн хороо хүн ам, орон сууцны 2015 оны завсрын тооллогын үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий Хороо (цаашид Хороо гэх) байгуулж ажиллана.

Хорооны үйл ажиллагааны зорилго нь хүн ам, орон сууцны завсрын тооллогын бэлтгэл ажлыг хангуулах, үндэсний хэмжээнд удирдан зохион байгуулж явуулах, үр дүнг нэгтгэн гаргахад нэгдсэн хяналт тавьж, удирдан чиглүүлэх, тооллогод тодорхой үүрэгтэйгээр оролцох яам, агентлагуудын болон орон нутгийн комиссын ажлын уялдаа холбоо, тэдгээрийн үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар хангахад чиглэнэ.

Хороо нь үйл ажиллагаандаа Монгол Улсын “Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хууль, холбогдох бусад хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан баримт бичгийг удирдлага болгон мөрдөж ажиллана.

Аймаг, нийслэлийн тооллогын комисс. Аймаг, нийслэлд тооллогын комисс ажиллах бөгөөд тэдгээрийн зорилго нь хүн ам, орон сууцы 2015 оны завсрын тооллогын бэлтгэлийг харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд хангаж, ХАӨМС-гийн бүрдэлтийг бүрэн дуусгах, тооллогод тодорхой үүрэгтэйгээр оролцох байгууллагуудын ажлын уялдаа, холбоог нэгдсэн зохицуулалтаар хангахад оршино.

Монгол Улсын “Хүн ам, орон сууцны тооллогын тухай” хуулийн 13 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасны дагуу аймаг, нийслэлийн тооллогын комисс дараах үүрэгтэй байна. Үүнд:

1. Тооллогоор хүн ам, орон сууцны талаарх мэдээллийг зохих журмын дагуу тухайн нутаг дэвсгэртээ цуглуулах ажлыг зохион байгуулах
2. Тооллогын ажилтныг гэрээгээр авч ажиллуулах, шаардлагатай сургалт явуулах, ажлын нь үр дүнг тооцох
3. Хороо болон Үндэсний статистикийн хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх
4. Тооллогын мэдээллийн үзүүлэлтийг нэгтгэж, дээд шатны байгууллагад хүргэх
5. Бусад үүрэг.

Сум, дүүргийн тооллогын комисс. Аймаг, нийслэлийн тооллогын комисс харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд ХАӨМС-гийн бүрдэлтийг бүрэн хийх чиг үүрэг бүхий комиссыг сум, дүүрэгт байгуулж ажиллуулна. Нийслэлийн хувьд хороонд түр товчоо байгуулж болно.

Тооллогын комисс, түр товчоо нь орон тооны бус байх бөгөөд тооллогын комиссыг байгуулахдаа харьяалах нутаг дэвсгэртээ завсрын тооллогын бэлтгэлийг ханган зохион байгуулж явуулахад зайлшгүй оролцох байгууллагуудын төлөөллийг бүрэн хамруулах, уялдуулан зохицуулах чиглэл баримтална.

Мэдээлэл цуглуулагч (Гэрээт ажилтан). Завсрын тооллогын мэдээлэл цуглуулагч буюу гэрээт ажилтан нь тогтоосон хугацаанд ХАӨМС-гийн мэдээллийг баяжуулж, бүрдэлтийг бүрэн хийх үүрэгтэйгээр анхан шатны нэгжид 2015 оны 6-р сараас 12-р сарыг дуустал хугацаанд хувь хүний нууцлалыг хангах, шаардлагыг бүрдүүлэх гэрээний дагуу ажиллана.

Гэрээт ажилтан нь иргэн, өрхийн мэдээллийг иж бүрэн шалгасны үндсэн дээр ХАӨМС-д нэгтгэж, өрхийн байршлыг зааврын дагуу тэмдэглэх үндсэн үүрэгтэй байна. Тус ажилтан аймаг, нийслэлийн тооллогын комиссоос өгсөн үүрэг, даалгаврыг тухай бүр гүйцэтгэж ажиллана.

6. Мэдээллийн үзүүлэлт

“Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хуулийн 11.1-д заасан дараах үзүүлэлтүүдийг завсрын тооллогоор цуглуулна. Үүнд:

1. Хүн ам зүй, нийгмийн үзүүлэлт:
 - Ургийн овог, эцэг/эх/-ийн нэр, нэр
 - Төрсөн он, сар, өдөр
 - Нас, хүйс
 - Яс үндэс
 - Иргэний харьяалал
 - Боловсролын түвшин
2. Газар зүй, шилжих хөдөлгөөний үзүүлэлт:
 - Төрсөн газар
 - Байнга болон тооллогын вед оршин суугаа газар
3. Эдийн засгийн үзүүлэлт:
 - Ажил эрхлэлтийн байдал
 - Ажилгүйдэл, түүний шалтгаан
4. Орон сууцны нөхцөлийн үзүүлэлт:
 - Сууцны төрөл
 - Сууцны талбай
 - Усан хангамж
 - Хог зайлуулалт
 - Цахилгаан, дулаан, харилцаа холбооны хангамж.

Үүнээс гадна хүн амын үзүүлэлтэд хөгжлийн бэрхшээл, орлогын хэлбэр, нийгмийн халамжид хамрагдалт, өрхийн үзүүлэлтэд өрхийн аж ахуйн үзүүлэлт болох мал, тэжээвэр амьтантай эсэх, газар, тариалан эрхэлдэг эсэх,

үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг эсэх болон тээврийн хэрэгсэлтэй эсэх, компьютертэй эсэх, интернеттэй эсэх гэсэн үзүүлэлтүүд мөн хамаарна.

Түүнчлэн гадаад улсад суугаа Монгол улсын иргэдийн мэдээллийг дараах үзүүлэлтээр цуглуулна. Үүнд:

- Ургийн овог, эцэг/ эхийн нэр, өөрийн нэр
- Регистрийн дугаар
- Хүйс
- Нас
- Яс үндэс
- Төрсөн газар улсын нэр, Монгол Улсад төрсөн бол аймаг, нийслэлийн нэр
- Байнга суугаа улсын нэр
- Байнга суугаа хотын нэр
- Гадаад улсад суугаа хугацаа
- Явсан зорилго
- Боловсролын түвшин
- Гэрлэлтийн байдал
- Хөдөлмөр эрхлэлтийн байдал
- Монголд хамгийн сүүлд байнга сууж байсан аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр

7. Ангилал, код

Завсрын тооллогын үзүүлэлтийн ангилал, кодыг олон улсын зөвлөмж, төрийн захиргааны бусад байгууллагуудын захиргааны мэдээллийн санд мөрдөж буй албан ёсны ангилал, кодтой нийцүүлж ашиглана. Үүнд:

- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код
- Хот, тосгоны ангилал, код
- Дэлхийн улс орнуудын код
- Шашны ангилал, код
- Үндэстэн, ястны код
- Боловсролын түвшний ангилал, код
- Гэрлэлтийн байдлын код
- Хөдөлмөр эрхлэлтийн байдлын ангилал, код
- Сууцны төрлийн код
- Цахилгааны эх үүсвэрийн код
- Халаалтын эх үүсвэрийн код
- Бохир ус зайлуулалтын код
- Хатуу хог, хаягдал зайлуулалт код

8. Технологи

ХАӨМС-г төрийн захиргааны бусад байгууллагуудын захиргааны мэдээллийн сантай уялдуулах. Завсрын тооллогын мэдээлэл цуглуулалт ХАӨМС-гийн мэдээллийг сайжруулах хүрээнд хийгдэнэ. ХАӨМС-г төрийн захиргааны бусад байгууллагуудын захиргааны мэдээллийн сантай уялдуулах ажлыг зохион байгуулна. Иргэний регистрийн дугаарт үндэслэн мэдээллийн сангуудын тулгалтыг хийнэ. Тухайлбал,

- УБЕГ-ын Иргэний мэдээллийн сан, ЭМСЯ-ны Төрөлт, Нас баралтын сан
- БСШУЯ-ны Ерөнхий боловсролын сургуулийн мэдээллийн сан, Төрийн сан, Сургуулийн өмнөх боловсролын мэдээллийн сан
- БХЯ-ны Хугацаат болон гэрээт цэргийн сан
- ХХЕГ-ын Хилийн цэргийн сан
- ШШГЕГ-ын Хоригдол, сэжигтний сан
- ЦЕГ-ын Дотоодын цэрэг болон орон гэргүй иргэдийн сан
- ИХШХЕГ-ын Гадаадад оршин суугаа Монгол улсын харьяат иргэдийн сан, Монгол Улсад оршин суугаа гадаадын иргэдийн сан
- ГХГЗЗГ-ын Хаягийн сан, Газрын нэгдмэл сан
- НХҮЕГ-ын Өрхийн амьжиргааг тооцох мэдээллийн сан, Асрамжийн мэдээллийн сан (ахмад настан, хүүхэд)
- НДЕГ-ын Нийгмийн даатгалын сан, Өрхийн эрүүл мэндийн даатгалын сан
- Бусад мэдээллийн сан

Интернетээр бүртгэх. Гадаадад оршин суугаа Монгол Улсын харьяат иргэдийн мэдээллийг тэдний регистрийн дугаарыг үндэслэн интернетээр бүртгэх ажлыг зохион байгуулна.

Таблет. Иргэдийн ХАӨМС дахь мэдээллийг баяжуулах, хяналт, мониторинг хийхэд электрон асуулга боловсруулж, таблет төхөөрөмж ашиглана.

Иргэн өөрийн мэдээллээ баталгаажуулах. Монгол Улсын иргэн овог, нэр, регистрийн дугаараар ХАӨМС-д нэвтэрч, өөрийн болон өрхийн гишүүдийн мэдээллээ хянаж, засварлуулах боломжийг бүрдүүлнэ. Өөрөөр хэлбэл, иргэн өөрийн болон өрхийн мэдээллээ зөвхөн харах эрхтэйгээр регистрийн дугаараар мэдээллийн санд нэвтрэх бөгөөд мэдээлэл үнэн зөв тохиолдолд програмын орчинд баталгаажуулалт хийнэ. Хэрэв баяжуулалт болон засварлалт хийх шаардлагатай бол хүсэлтийг програмын орчинд гаргана. Ингэснээр холбогдох баг, хорооны ХАӨМС-г хариуцсан ажилтан хүсэлт гаргасан иргэнтэй холбогдож баяжуулалт хийнэ.

Газар зүйн мэдээллийн систем. ХАӨМС-д бүртгэлтэй өрхийн байршлыг дараах 2 аргаар тодорхойлно. Үүнд:

1. Бэлтгэгдсэн ажилтнууд төв суурин газрын өрхийн хаягийн мэдээллийг ХАӨМС-д хавсаргасан цахим кадастрын зураг дээр газрын зургийн програмын тусламжтайгаар тодорхойлно.

2. Баг, хороодын гэрээт ажилтан төв суурин газрын хаяг тодорхойгүй болон хөдөө байрлалтай өрхүүдийн байршлыг ХАӨМС-д хавсаргасан цахим хиймэл дагуулын болон кадастрын газрын зураг дээр газрын зургийн програмын тусламжтайгаар тодорхойлно.

Өрхийн байршлыг тодорхойлсноор өрхийн газар зүйн мэдээллийн санг үүсгэж, завсрын тооллогын үр дүн гаргахад ашиглана.

9. Сурталчилгаа

Хүн ам, орон сууцны 2015 оны завсрын тооллого Монгол Улсын хувьд анхны бүртгэлд суурилсан тооллого болох тул сурталчилгааг нийт хүн ам болон тооллогын үр дүнг хэрэглэгч гэсэн 2 түвшинд хийнэ.

Хүн амын дунд явуулах сурталчилгаа. Хүн амыг завсрын тооллогын талаарх мэдлэг мэдээллээр хангах, бүртгэлд суурилсан тооллогын зорилго, ач холбогдлыг таниулахад чиглэнэ.

Үүний тулд сургалтын арга хэрэгсэл, хэвлэл мэдээлийн хэрэгслээр мэдээлэл түгээх, төлбөрт сурталчилгаа, удирдлагын тайлбар, ярилцлага зохион байгуулах, бусад нээлттэй үйл ажиллагаа зохион байгуулна. Түүнчлэн, ҮСХ-ны цахим хуудсанд завсрын тооллогын талаарх бүхий л мэдээллийг тогтмол байршуулна.

Нийт хүн амын дунд явуулах сурталчилгаа нь дараах зорилтыг хангасан байна. Үүнд:

1. Тооллогын үндсэн зорилго, ач холбогдлыг олон нийтэд ойлгуулах
2. Тооллогын хамрах хүрээг бүрэн хангаж, өргөжүүлэх
3. Тооллогод хамрагдахын ач холбогдлыг иргэдэд таниулах
4. Тооллогын хамрагдалт, мэдээллийн үнэн, зөв, бодит байдлыг хангахад орших болно.

Сурталчилгааг телевиз, радио, ФМ зэрэгт ярилцлага хийх, бэлтгэгдсэн мэдээлэл байнга өгөх, телевизийн шторк, сурталчилгааны самбар байршуулах бөгөөд дараах чиглэлийг баримтлан зохион байгуулж явуулна. Үүнд:

- Хүн ам, өрхийн бүртгэлийн явцын талаар болон мэдээллийн баяжуулалт, бүртгэлийн ач холбогдол
- ХАӨМС-гийн мэдээллийг баяжуулах, бүртгэлийн ач холбогдлыг таниулах "Нээлттэй хаалганы өдөрлөг"-ийг баг, хороонд нэгдсэн графикайн дагуу холбогдох журмаар зохион байгуулах
- "ХАӨМС-д иргэд онлайнаар хандаж, мэдээллээ баталгаажуулах талаарх сурталчилгааны материал боловсруулж тархаах зэрэг ажлууд багтана.

Түүнчлэн, нийт хүн амын дунд үүрэн утасны операторуудыг ашиглан ХАӨМС-гийн талаарх мэдээлэл, зохион байгуулагдаж байгаа үйл ажиллагаа, үйл ажиллагаанд идэвхтэй оролцохыг уриалсан мэдээллийг утсаар илгээх ажил зохион байгуулна.

Хэрэглэгчдэд зориулсан ухуулга сурталчилгаа. Завсрын тооллогыг регистрт суурилсан аргаар зохион байгуулж, бүрдүүлж буй онлайн ХАӨМС-г төрийн байгууллагууд шаардлагатай үйл ажиллагаандаа нууцлал, аюулгүй байдлыг хангасны үндсэн дээр ашиглах, хэрэглэх талаарх сурталчилгааны материалыг боловсруулж гаргана. Энэхүү ажлыг амжилттай хийж гүйцэтгэснээр байгаа нөөц бололцооны хүрээнд хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн мэдээлэл цуглуулах, боловсруулах, мэдээллийн бааз бүрдүүлэх ажлуудыг хийж гүйцэтгэх болно.

Хэрэглэгчид нь Засгийн газар, салбарын яамд, агентлаг, засаг захиргааны бүх шатны байгууллагууд, их, дээд сургуулиуд, судалгааны байгууллагууд, төрийн бус байгууллагууд, хувийн хэвшил, иргэд болон гадаадын түнш, хэрэглэгчид байна.

10. Туршилт

Завсрын тооллогын туршилтаар судалгааны бүхий л үйл ажиллагааг процессын хувьд туршина. Хүн ам, өрхийн мэдээллийн чанар, баяжилтыг баг, хороонд түүвэрлэн хянаж, холбогдох сангуудын мэдээлэлтэй уялдуулсны үндсэн дээр үр дүнгийн хүснэгтүүдийг нэг бүрчлэн гаргаж, тэдгээрт чанарын шалгалт, явуулахад гарах алдаа, дутагдал бүрийг тодорхойлно. Гарсан үр дүнгийн талаар танилцуулга бэлтгэн завсрын тооллогын Хороо болон ҮСХ-ны удирдлагад танилцуулж, аймаг, нийслэлийн тооллогын комиссуудад гарсан үр дүн, түүнтэй холбогдолтой үүрэг даалгавар, заавар зөвлөмжийг шуурхай хүргүүлнэ.

Туршилтын тооллогыг 2015 оны 10-р сард зохион байгуулж, ХАӨМС-гаас үр дүнг гаргана.

11. Мэдээлэл цуглуулалт, хяналт, мониторинг

Завсрын тооллогын хүрээнд ХАӨМС-гийн баяжилтад таблет төхөөрөмж ашиглан мэдээллийг тулгах байдлаар үнэлгээ хийнэ. Тус мониторингийн ажлыг аймаг, нийслэлийн тооллогын комисстой хамтран 2015 оны 6, 10-р сард зохион байгуулна. Хяналтаар ХАӨМС-ийн хамралт, үзүүлэлтийн чанарыг шалгаж, үнэлгээ гаргана.

12. Хяналтын тооллого

Завсрын тооллогын хяналтын тооллого (цаашид хяналтын тооллого гэх) нь бие даасан, хараат бус үнэлгээний гол арга юм. Түүнчлэн тооллогын үр дүнг ашиглахад үнэлгээний итгэлцүүр болох бөгөөд дараа дараагийн тооллогод анхаарал хандуулах, үүсэж болзошгүй асуудлыг шийдвэрлэх арга замыг санал болгох зөвлөмж, дүгнэлт гаргана.

Хяналтын тооллогын зорилго тооллогын хамралтын болон агуулгын алдааг тодорхойлох, сонгосон асуултуудаар завсрын тооллого болон хяналтын тооллогод өгсөн хариултыг харьцуулах, тооллогын нэгж, түүний хамрах хүрээг

тооллого хооронд явагдах хүн ам, нийгэм, эдийн засгийн түүвэр судалгаанд ашиглахад үнэлгээ өгөх зэрэгт чиглэгдэнэ.

12.1 Түүврийн хүрээ, хэмжээ

Түүврийн хүрээг ХАӨМС-гаар тогтооно. Түүврийн хэмжээг үндэсний хэмжээнд төлөөлүүлэн тооцох бөгөөд төв суурин газрын нийт өрхийн 1 хувийг хамруулан 2015 оны 12 сард зохион байгуулна.

12.2 Баримтлах зарчим

Хяналтын тооллогыг байршлын хувьд ялгаатайгаар зохион байгуулж явуулна.

- Улаанбаатар хотод ҮСХ-ны Бүртгэл, тооллого, мэдээллийн газрын Тооллогын товчоо, нийслэлийн тооллогын комисстой хамтарч зохион байгуулна. Энэ хүрээнд хяналтын тооллогод сонгогдсон өрхийн мэдээллийг ХАӨМС-гийн мэдээлэлтэй зэрэгцүүлэн үнэлгээ хийх хүнийг гэрээгээр авч ажиллуулна.
- Аймгийн төв, тосгон, сумын төвд сонгогдсон өрхийн мэдээллийг ХАӨМС-гийн мэдээлэлтэй тулгах ажлыг аймгийн тооллогын комисс хариуцаж зохион байгуулна. Ингэхдээ тооллогын гэрээт ажилтнуудыг сэлгэн ажиллуулна.
- Хөдөөгийн багуудын түвшинд хяналтын тооллогыг хагас болон бүтэн жилийн мал тооллоготой хамтатган зохион байгуулах чиглэл баримтална.

12.3 Мэдээллийг боловсруулах

Хяналтын тооллогын үр дүнг ХАӨМС-тай тулгалт хийх програм хангамжийг боловсруулж, ХАӨМС-гаас сонгогдсон өрх, хүн амын мэдээллийг хяналтын тооллогын мэдээллээр засварлаж, мэдээллийн чанарыг сайжруулна.

12.4 Үнэлгээний үзүүлэлтийн аргачлал

НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн комисс, Статистикийн хэлтсээс эрхлэн гаргасан “Хяналтын тооллого явуулах арга зүй, аргачлал” гарын авлагад дурьдсан үзүүлэлтүүдийг тооцож хамралтын болон агуулгын алдаануудыг гаргана.

Зарим тодорхой зорилгын үүднээс үнэлгээний үр дүн нь тооллогын үр дүнгийн хүснэгтийг тайлбарлахад хэрэгтэй байж болно. Тооллогод үнэлгээ өгч, хүндрэлтэй асуудлуудыг тодорхойлж дараа, дараагийн тооллогод анхаарах болон тооллогын хэрэглэгчдийн хэрэгцээг бүрэн хангах, үнэн зөв мэдээллийг цуглуулахад оршино.

13. Боловсруулалт, үр дүнгийн хүснэгт

ХАӨМС дахь өрх болон өрхийн гишүүдийн мэдээлэлд үндэслэн хүн ам, орон сууцны 2015 оны завсрын тооллогын үр дүнг хүн амын 26 хүснэгт, орон сууцны 45 хүснэгтийн дагуу гаргана.

Тус үр дүнд завсрын тооллогын үндсэн үзүүлэлтийн, зарим түүвэр судалгааны болон орон нутгийн хэрэгцээнд боловсруулсан хүснэгтүүд багтана.

14. Тархаах хэвлэн нийтлэх

Завсрын тооллогын үр дүнг дараах үе шатаар гаргаж тархаана.

1	Завсрын тооллогын хүн амын нэгтгэл (Урьдчилсан дүн)	2016 оны 2 дугаар сар
2	Завсрын тооллогын үндсэн үр дүн (Хүн ам, орон сууцны 2010 оны ээлжит тооллогоор гаргасан хүснэгтүүдийг боломжит түвшингээр ХАӨМС-ийн үзүүлэлтийн хүрээнд гаргах)	2016 оны 4 дүгээр сар
3	Завсрын тооллогын нэгдсэн тайлан (Завсрын тооллогын зохион байгуулалт, тооллого хоорондын өөрчлөлтөд дүн шинжилгээ хийсэн нэгдсэн тайлан)	2016 оны 6 дугаар сар
4	Завсрын тооллогын үр дүнд суурилсан сэдэвчилсэн судалгаа (ХА-ын хэтийн тооцоо, нас, хүйсийн бүтцийн шинжилгээ, түүнчлэн өрхөд суурилсан судалгааны түүврийн хүрээг орон зайн түвшинд төлөвлөх бололцоог бүрдүүлэх зэрэг)	2016 оны 12 дугаар сар

15. Тооллогын үйл ажиллагааг баримтжуулах

Тооллогын бүхий л үе шатны, бүх төрлийн үйл ажиллагааг баримтжуулж, тооллогын түүхийн лавлагаа бүрдүүлэх ажлыг Тооллогын товчоо хийж гүйцэтгэнэ. Тооллогын товчооноос тооллогын баримтжуулсан бичиг баримтаар тусгайлан товхимол, тайлан бэлтгэж гаргана.

16. Бусад асуудал

16.1 Нууцлал, аюулгүй байдал

ХАӨМС-гийн нууцлалыг “Хувь хүний нууцын тухай” хуулийн 4-р зүйлийн 1.4, 2.4, тус хуулийн 5-р зүйл, “Статистикийн тухай” хуулийн 22-р зүйлийн 6 дахь заалтуудын дагуу хангана.

ХАӨМС–гийн системийн зохицуулагчийн үүргийг Үндэсний статистикийн хороо (цаашид ҮСХ гэх) хариуцах бөгөөд системийн зохицуулагч системийн хэрэглэгчийг бүртгэнэ.

ҮСХ-ноос зөвшөөрөгдсөн хэрэглэгч, буюу системд хандаж буй зөвшөөрөгдсөн хүн бүр тусгай нууцлалтай хэрэглэгчийн нэр, нууц үгтэй байна. Хэрэглэгч өөрийн нэр, нууц үгийг бусдад дамжуулахгүй бөгөөд мэдээллийн санг зөвхөн албан хэрэгцээнд ашиглана. ХАӨМС-д нэвтэрснээс эхлээд гарах хүртэлх бүх үйлдлийг хэрэглэгчийн нэрээр хадгалж хянах болно. Иймд бүх үйлдэл цаг хугацаатай хадгалагдаж хянагдана.

Системийн хэрэглэгч нь үндсэн 4 түвшинд ангилагдана. Үүнд:

- Улсын түвшний хэрэглэгч – улсын хэмжээний ХАӨМС-д хандах, харах, хянах эрх бүхий хэрэглэгч (ҮСХ)
- Аймаг/нийслэлийн түвшний хэрэглэгч – холбогдох аймаг/нийслэлийн ХАӨМС-д хандах, харах, хянах, эрх бүхий хэрэглэгч
- Сум/дүүргийн түвшний хэрэглэгч – харьяа сум/дүүргийн ХАӨМС-д хандах, харах, хянах эрх бүхий хэрэглэгч
- Баг/хорооны түвшний хэрэглэгч – харьяа баг/хорооны хэмжээний ХАӨМС-д хандах, харах, засварлах эрх бүхий хэрэглэгч нар байна.

Эхний 3 түвшний хэрэглэгч ХАӨМС-г засварлах эрхгүй, зөвхөн харах, хянах эрхтэй бол сүүлийн түвшний хэрэглэгч буюу баг/хорооны түвшний хэрэглэгч засварлах эрхтэй.

16.2 Төсвийн бүтэц

Хүн ам, орон сууцны 2015 оны завсрын тооллогын төсвийг дараах задаргаагаар зарцуулна (хүснэгт 1). Үүнд:

Завсрын тооллогын бэлтгэлийг хангах төвлөрсөн төсвийн зардал

1. Удирдах хорооны үйл ажиллагааны зардал
2. Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтэр, гарын авлага хэвлэх зардал
3. Багцын зардал
4. Тооллогын нутаг дэвсгэрийн нэгжийн зураглалын зардал
5. Програмын шинэчлэлт
6. Аймаг, нийслэлийн комиссын зөвлөлдөх уулзалт
7. Тооллогын багц, газрын зураглал хүргүүлэх зардал
8. Сурталчилгааны зардал
9. Тоног төхөөрөмжийн зардал (Tablet)
10. Туршилтын тооллого, хяналт (2 удаа)
11. Хяналтын тооллого (Улаанбаатар)

Орон нутгийн төсвийн зардал

1. Завсрын тооллогын үеийн үйл ажиллагааны зардал
2. Тоолох үеийн тоологчийн унааны зардал
3. Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтэр хэвлэх зардал
4. Сум, дүүрэг, баг, хорооны түр товчооны үйл ажиллагааны зардал
5. Бүх шатны сургалтын зардал

6. Яамд болон холбогдох байгууллагын тооллогын үйл ажиллагааны зардал
7. Тооллогын сурталчилгааны зардал (УБ ороогүй)
8. Тоног төхөөрөмжийн зардал
9. Вирусын эсрэг програмын зардал
10. Мониторинг хийх зардал
11. Хяналтын тооллого

16.3 Төлөвлөлт

№	Үйл ажиллагаа	Хугацаа	
		Эхлэх	Дуусах
1	Бэлтгэл, сангуудыг холбох	2015.04	2015.06
2	Туршилт	2015.10	2015.10
3	Сургалт	2015.06	2015.06
4	Сурталчилгаа	2015.05	2015.12
5	Интернет бүртгэл	2015.10	2015.12
6	Боловсруулалт	2015.07	2016.02
7	Хяналт, мониторинг	2015.06	2015.12
8	Хяналтын тооллого	2015.12	2015.12
9	Үр дүн, тайлан	2016.02	2016.06
10	Мэдээлэл тархаалт	2016.06-сараас хойш	
11	Сэдэвчилсэн судалгаа		

ХАВСРАЛТ

Улсын хороо, аймаг, нийслэлийн комиссын бүрэлдэхүүн

Улсын хорооны бүрэлдэхүүн

Хорооны дарга:

Үндэсний статистикийн хорооны дарга

Хорооны орлогч дарга:

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга

Үндэсний статистикийн хорооны Бүртгэл, тооллого, мэдээллийн газрын дарга

Хорооны гишүүд:

Гадаад харилцааны яамны төрийн нарийн бичгийн дарга

Хууль зүйн яамны төрийн нарийн бичгийн дарга

Батлан хамгаалах яамны төрийн нарийн бичгийн дарга

Хил хамгаалах ерөнхий газрын дарга

Цагдаагийн ерөнхий газрын дарга

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга

Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын дарга

Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга

Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын дарга

Эрүүл мэнд, спортын яамны харьяа Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төвийн захирал

Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч

Хорооны нарийн бичгийн дарга:

Үндэсний статистикийн хорооны

Бүртгэл, тооллого, мэдээллийн газрын Тооллогын товчооны дарга

Нийслэлийн тооллогын комиссын бүрэлдэхүүн

Тооллогын комиссын дарга:

Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч

Тооллогын комиссын орлогч дарга:

Нийслэлийн статистикийн газрын дарга

Тооллогын комиссын гишүүд:

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа,

үйлчилгээний хэлтсийн дарга

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга
Нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний газрын дарга
Нийслэлийн Нийгмийн халамж үйлчилгээний газрын дарга
Боловсролын газрын дарга
Эрүүл мэндийн газрын дарга
Улсын бүртгэлийн газрын дарга
Өмчийн харилцааны газрын дарга
Мэдээллийн технологийн газрын дарга
Улаанбаатар хотын Цагдаагийн газрын дарга
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны дарга
Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газрын дарга
Архивын газрын дарга
Тээврийн газрын дарга
Соёл, урлагийн газрын дарга
Нийтлэг үйлчилгээний газрын дарга

Тооллогын комиссын нарийн бичгийн дарга:

Нийслэлийн Статистикийн газрын хүн ам, нийгмийн статистикийн мэдээлэл хариуцсан мэргэжилтэн

Аймгийн тооллогын комиссын бүрэлдэхүүн

Тооллогын комиссын дарга:

Аймгийн засаг дарга

Тооллогын комиссын орлогч дарга:

Аймгийн статистикийн хэлтсийн дарга

Тооллогын комиссын гишүүд:

Аймгийн иргэдийн төлөөлөгчдын хурлын нарийн бичгийн дарга
Аймгийн ИТХ-ын Нийгмийн хөгжлийн байнгын хорооны дарга
Засаг даргын Тамгын газрын дарга
ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга
ЗДТГ-ын Цэргийн штабын дарга
Боловсрол, соёлын газрын дарга
Эрүүл мэндийн газрын дарга
Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга
Цагдаагийн газрын дарга
Улсын бүртгэлийн хэлтсийн дарга
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны дарга
Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний бүсийн газрын дарга
Нийгмийн даатгалын хэлтсийн дарга
Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн дарга
Татварын хэлтсийн дарга

Тооллогын комиссын нарийн бичгийн дарга:

Аймгийн Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Үр дүнгийн хүснэгтийн жагсаалт

Бүлэг	Дэс дугаар	Хүснэгтийн нэр	Хүснэгтийн задаргаа	Түвшин			
				Улсын дүн	Аймаг, нийслэл	Сум, дүүрэг	Баг, хороо
Хүн амын хүснэгтүүд	1	Монгол Улсын хүн амын тоо, нас, хүйсээр	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
	2	Бэлэн хүн амын тоо, нас, хүйсээр	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
	3	Суурин хүн амын тоо, нас, хүйсээр	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
	4	Суурин хүн амын тоо, нас, хүйс, засаг захиргааны нэгжээр	Бүгд Эрэгтэй Эмэгтэй Хот Хөдөө	√	√	√	√
	5	Хүн амын тоо, нас, байршлаар	Бүгд Эрэгтэй Эмэгтэй	√	√	√	√
	6	Хүн амын тоо, харьяалал, ястан үндэстэн, насны бүлгээр	Бүгд Эрэгтэй Эмэгтэй Хот Хөдөө	√	√	√	√
	7	Хүн амын тоо, харьяалал, ястан, үндэстэн, хот, хөдөө, хүйсээр	Бүгд	√	√	√	√
	8	Арван тав, түүнээс дээш насны хүн амын тоо, насны бүлэг, гэрлэлтийн байдлаар	Бүгд Хот Хөдөө Эрэгтэй Эмэгтэй	√	√	√	√
	9	Хүн амын тоо, өрхийн тэргүүлэгчийн хамаарал, насны бүлэг	Бүгд Хот Хөдөө Эрэгтэй Эмэгтэй	√	√	√	√

10	Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, нас, хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, хүйсээр	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
11	Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, нас, хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, хүйсээр	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
12	Олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, нас, хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, хүйсээр	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
13	Зургаа, түүнээс дээш насны хүн амын тоо, нас, боловсролын түвшнээр	Бүгд Хот Хөдөө Эрэгтэй Эмэгтэй	√	√	√	√
14	Зургаа, түүнээс дээш насны суурин хүн амын тоо, боловсролын түвшин, хот, хөдөө, хүйсээр	Бүгд	√	√	√	√
15	Хоёроос гучин есөн насны хүн амын тоо, сургуульд сурдаг (цэцэрлэгт хүмүүждэг) эсэх, сургуульд сурдаггүй хүн амын хөдөлмөр эрхэлдэг эсэх, хүйс, насаар	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
16	Хоёроос гучин есөн насны хүн амын тоо, аймаг, нийслэл, сургууль хамрагдалтын байдлаар	Бүгд Эрэгтэй Эмэгтэй	√	√	√	√
17	Хоёроос гучин есөн насны хүн амын тоо, нас, сургууль хамрагдалтын байдлаар	Бүгд Эрэгтэй Эмэгтэй	√	√	√	√
18	Арван тав ба түүнээс дээш насны хүн амын эдийн засийн идэвх, байршил, хүйсээр	Бүгд	√	√	√	√
19	Арван тав ба түүнээс дээш насны хүн амын эдийн засийн идэвх, насны бүлгээр	Бүгд Хот Хөдөө Эрэгтэй Эмэгтэй	√	√	√	√
20	Арван тав ба түүнээс дээш насны хүн амын тоо, насны бүлэг, хөдөлмөр эрхлэлтийн статусаар	Бүгд Хот Хөдөө Эрэгтэй Эмэгтэй	√	√	√	√

	21	Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амын тоо, насны бүлэг, боловсролын түвшнээр	Бүгд Хот Хөдөө Эрэгтэй Эмэгтэй	√	√	√	√
	22	Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амын тоо, насны бүлэг, гэрлэлтийн байдлаар	Бүгд Хот Хөдөө Эрэгтэй Эмэгтэй	√	√	√	√
	23	Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэггүй хүний тоо, шалтгаан, насны бүлгээр	Бүгд Хот Хөдөө Эрэгтэй Эмэгтэй	√	√	√	√
	24	15, түүнээс доош насны ажил эрхэлдэг хүн амын тоо, сургуульд сурдаг эсэхээр	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
	25	Арван тав, түүнээс дээш настай хүн амын тоо, орлогын хэлбэр, байршлаар	Бүгд	√	√	√	√
	26	Арван тав, түүнээс дээш настай хүн амын тоо, орлогын хэлбэрээр	Бүгд Эрэгтэй Эмэгтэй	√	√	√	√
Өрхийн хүснэгтүүд	1	Өрх, өрхөд тоологдсон хүн амын тоо, ам бүлийн тоо, өрхийн хэлбэрээр	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
	2	Өрхийн тоо, өрхөд тоологдсон суурин хүн амын тоо, 18 хүртэлх насны хүүхдийн тоогоор	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
	3	Өрхийн тоо, өрхийн аж ахуйн үзүүлэлтээр	Бүгд	√	√	√	√
	4	Өрхийн тоо, сууцны төрлөөр	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
	5	Байшинд амьдардаг өрх, байшингийн төрөл, сууцны эзэмшлийн хэлбэрээр	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
	6	Байшинд амьдардаг өрх, өрхөд тоологдсон суурин хүн амын тоо, байшингийн төрөл, сууцны эзэмшлийн хэлбэрээр	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
	7	Байшинд амьдардаг өрх, өрхөд тоологдсон суурин хүн амын тоо,	Бүгд Хот	√	√	√	√

	сууцны талбайн хэмжээгээр	Хөдөө				
8	Байшинд амьдардаг өрх, өрхөд тоологдсон суурин хүн амын тоо, усан хангамжийн төрлөөр	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
9	Байшинд амьдардаг өрх, өрхөд тоологдсон суурин хүн амын тоо, цахилгааны эх үүсвэрээр	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
10	Байшинд амьдардаг өрх, өрхөд тоологдсон суурин хүн амын тоо, халаалтын эх үүсвэрээр	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
11	Байшинд амьдардаг өрх, өрхөд тоологдсон суурин хүн амын тоо, бохир ус зайлуулалтаар	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
12	Байшинд амьдардаг өрх, өрхөд тоологдсон суурин хүн амын тоо, хатуу хог, хаягдал зайлуулалтаар	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
13	Байшинд амьдардаг өрх, байшингийн төрөл, бохир ус зайлуулалтаар	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
14	Байшинд амьдардаг өрх, байшингийн төрөл, хатуу хог, хаягдал зайлуулалтаар	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
15	Байшинд амьдардаг өрхийн, байшингийн төрөл, эзэмшлийн хэлбэрээр	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
16	Байшинд амьдардаг өрхийн, байшингийн төрөл, сууцны талбайн хэмжээгээр	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
17	Байшинд амьдардаг өрх, байшингийн төрөл, эзэмшлийн хэлбэр, усан хангамжийн төрлөөр	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
18	Байшинд амьдардаг өрх, байшингийн төрөл, цахилгааны эх үүсвэрээр	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
19	Байшинд амьдардаг өрх, байшингийн төрөл, халаалтын эх үүсвэрээр	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
20	Гэрт амьдардаг өрх, гэрийн тоо, гэрийн ханын тоогоор	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
21	Гэрт амьдардаг өрх, өрхөд тоологдсон хүн амын тоо, гэрийн ханын тоогоор	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
22	Гэрт амьдардаг өрх, өрхөд	Бүгд	√	√	√	√

	тоологдсон суурин хүн амын тоо, сууцны эзэмшлийн хэлбэрээр	Хот Хөдөө				
23	Гэрт амьдардаг өрх, өрхөд тоологдсон суурин хүн амын тоо, цахилгааны эх үүсвэрээр	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
24	Гэрт амьдардаг өрх, бохир ус зайлуулалтаар	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
25	Гэрт амьдардаг өрх, өрхөд тоологдсон суурин хүн амын тоо, усан хангамжаар	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
26	Гэрт амьдардаг өрх, өрхөд тоологдсон суурин хүн амын тоо, халаалтын эх үүсвэрээр	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
27	Гэрт амьдардаг өрх, өрхөд тоологдсон суурин хүн амын тоо, хатуу хог, хаягдал зайлуулалтаар	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
28	Зориулалтын бус сууцанд амьдарч буй 6, түүнээс дээш насны суурин хүн амын тоо, нас, боловсролын түвшин, бичиг үсгийн мэдлэгээр	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
29	Зориулалтын бус сууцанд амьдарч буй 15, түүнээс дээш насны суурин хүн амын тоо, нас, гэрлэлтийн байдлаар	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
30	Орон гэргүй 6, түүнээс дээш насны суурин хүн амын тоо, нас, боловсролын түвшин, бичиг үсгийн мэдлэгээр	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
31	Орон гэргүй 15, түүнээс дээш насны суурин хүн амын тоо, нас, гэрлэлтийн байдлаар	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
32	Өрхөд тоологдсон 18 хүртэлх насны суурин хүн амын тоо, хүйс, эцэг, эхтэйгээ хамт амьдардаг байдлаар, сууцны төрлөөр	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
33	Өрх, өрхийн тэргүүлэгчийн хүйс, өрхөд тоологдсон суурин хүн амын тоо, насны бүлэг, сууцны төрлөөр	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
34	Өрх, өрхөд тоологдсон суурин хүн амын тоо, өрхийн хэлбэр, сууцны төрлөөр	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
35	Өрх, өрхөд тоологдсон суурин хүн амын тоо, эдийн засгийн идэвхийн	Бүгд Хот	√	√	√	√

	байдал, байшингийн төрлөөр	Хөдөө				
36	Орон гэргүй өрх, өрхийн тэргүүлэгчийн насны бүлэг, хүйсээр	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
37	Нийтээр амьдардаг суурин хүн амын тоо, сууцны талбай, орон сууцны зарим нөхцөлөөр	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
38	Нийтийн байранд амьдардаг суурин хүн амын тоо, орон сууцны зарим нөхцөлөөр	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
39	Нийтийн байранд амьдардаг суурин хүн амын тоо, сууцны талбайгаар	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
40	Мал тэжээвэр амьтантай өрх, өрхөд тоологдсон суурин хүн амын тоо	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
41	Газар тариалан эрхэлдэг өрх, өрхөд тоологдсон суурин хүн амын тоо, тариалангийн талбайгаар	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
42	Үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлдэг өрх, өрхөд тоологдсон суурин хүн амын тоо	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
43	Тээврийн хэрэгсэлтэй өрх, өрхөд тоологдсон суурин хүн амын тоо, тээврийн хэрэгслийн төрлөөр	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
44	Компьютер хэрэглэдэг өрх, өрхөд тоологдсон хүн амын тоо	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√
45	Интернет хэрэглэдэг өрх, өрхөд тоологдсон хүн амын тоо	Бүгд Хот Хөдөө	√	√	√	√

Хүн ам, орон сууцны 2015 оны завсрын тооллогын үйл ажиллагааны дэлгэрэнгүй төлөвлөгөө

Хийгдэх үйл ажиллагаа	Хамрах хугацаа													
	2015						2016							
	4	5	6	7	8	9	10	11	12	1	2	3	4	5
Тооллогын бэлтгэл ажлын үе														
1. Тооллогын хороо, комисс, түр товчоог байнгын үйл ажиллагаагаар хангах														
Суурин хүн амыг тодорхойлоход хэрэглэгддэг 6 сар /180 хоног/-ын ойлголтыг өөрчлөх талаар холбогдох хуулиудыг судалж, хуульд өөрчлөлт оруулах журамтай танилцаж, хуулийн үзэл баримтлал боловсруулах	4-р сар													
"Хүн ам, орон сууцны завсрын тооллогын үндсэн зарчим, арга зүй, зохион байгуулалт"-ыг боловсруулж, батлуулах	4-5-р сар													
Хүн ам, орон сууцны завсрын тооллогын төлөвлөгөөг боловсруулж, батлуулах	4-5-р сар													
Хүн ам, орон сууцны завсрын тооллогыг зохион байгуулах хороог байгуулж, ажлын удирдамж боловсруулж хүргүүлэх	4-р сар													
Хүн ам, орон сууцны завсрын тооллогыг зохион байгуулах хорооны хурал зохион байгуулах	5-р сар													
Завсрын тооллогыг аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороонд зохион байгуулж явуулах тооллогын комисс, түр товчооны ажиллах удирдамж боловсруулж, нэгдсэн чиглэл өгөх ажлыг зохион байгуулах	4-р сар													
Аймаг, нийслэл завсрын тооллогын комиссын хурал зохион байгуулах	5-р сар													
Хүн ам, орон сууцны завсрын тооллого зохион байгуулж явуулах талаар улс орнуудын туршлагаас судлах /Финлянд-Бүртгэлд суурилсан тооллого, интернэт, Турк-Хаягт суурилсан тооллого, гадаадад суугаа иргэдийн	4-р сар													

тооллого, web call, call center тооллого, Япон-Computer assistant/

2. Хүн ам, өрхийн мэдээллийн санг сайжруулах

<i>ҮСХ-ны түвшинд</i>	
ХАӨМС-ийн шивэлтийн алдаа, үзүүлэлтүүдийн бүрдэлтийг аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо, өрх, хүн ам бүрээр гаргаж, аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газарт хүргүүлж, алдааг нягтлуулах	5, 9-р сар
ХАӨМС-ийн шивэлтийн алдаа, үзүүлэлтүүдийн бүрдэлт, хамралтыг сайжруулах ажилд дэмжлэг үзүүлж ажиллах гэрээт ажилтны шалгуурыг тодорхойлж, гэрээний эх загварыг хүргүүлэх	4-р сар
Иргэн интернетээр ХАӨМС-аас өөрийн мэдээллээ шалгаж, хянах технологийн шийдлийг нэвтрүүлэх	5-р сар
Гадаадад удаан хугацаагаар суугаа иргэд интернетээр бүртгүүлэх, мэдээллээ шалгах асуудлыг шийдвэрлэх	6-р сар
<i>Аймаг, нийслэлийн түвшинд</i>	
Сум, дүүргийн тооллогын түр товчооны гишүүдийн сургалтыг холбогдох нэгжтэй хамтран зохион байгуулах /Аймаг, нийслэлийн засаг даргын тамгын газар/ ажилд зөвлөгөө өгч ажиллах	9-10-р сар
Аймаг, нийслэлийн статистикийн хэлтэсээс ХАӨМС-гийн өрхийн дугаар, регистрийн дугаарын давхардал, алдааг арилгаж, тодруулга хийсэн мэдээллийг авч, нягтлах, нэгтгэх, дахин тодруулга хийх	4-р сар
ХАӨМС-ийн шивэлтийн алдаа, үзүүлэлтүүдийн бүрдэлт, хамралтыг сайжруулах ажилд дэмжлэг үзүүлж ажиллах гэрээт ажилтны сургалтыг зохион байгуулах	5-р сар
ХАӨМС-ийн шивэлтийн алдаа, үзүүлэлтүүдийн бүрдэлт, хамралтыг сайжруулах ажилд дэмжлэг үзүүлж ажиллах гэрээт ажилтныг сонгон шалгаруулж, томилох	5-р сар

Иргэн интернетээр ХАӨМС-аас өөрийн мэдээллээ шалгаж, хянах технологийн шийдлийг нэвтрүүлэх	5-р сар																			
Гадаадад удаан хугацаагаар суугаа иргэд интернетээр бүртгүүлэх, мэдээллээ шалгах асуудлыг шийдвэрлэх	6-р сар																			
ХАӨМС-г сайжруулах ажлын хүрээнд лавлах утас ажиллуулах 1. ТТ-ноос Гэрээт ажилтанд нэгдсэн чиглэл өгөх 2. Гэрээт ажилтнууд иргэдтэй холбогдох	6-12-р сар																			

Мэдээллийн сантай уялдуулах

УБЕГ-ын Иргэний мэдээллийн сан	4-7-р сар																			
ЭМСЯ-ны Төрөлт, Нас баралтын сан	4-7-р сар																			
БХЯ-ны Жагсаалын цэргийн сан, ХЗЯ-ны Дотоодын цэргийн сан, ХХЕГ-ын Хилийн цэргийн сан, ШШГЕГ-ын Хоригдол, сэжигтний сан, ЦЕГ-ын орон гэргүй иргэдийн сан	4-7-р сар																			
ХЗЯ-ны ИХШХЕГ-ын Гадаадад урт хугацаагаар суугаа Монгол улсын харьяат иргэдийн сан, Монгол Улсад удаан хугацаагаар суугаа гадаадын иргэдийн сан	4-7-р сар																			
ГХГЗЗГ-ын Хаягийн сан, Газрын нэгдмэл сан	4-7-р сар																			
БСШУЯ-ны ЕБС мэдээллийн сан, Төрийн сан, СӨБ мэдээллийн сан	6-7-р сар																			
НХҮЕГ-ын ӨАТМС, Асрамжийн мэдээллийн сан (ахмад настан, хүүхэд)	6-7-р сар																			
НДЕГ-ын Нийгмийн даатгалын сан, Эдийн засгийн идэвхтэй хүн амын сан, Өрхийн эрүүл мэндийн даатгалын сан	6-7-р сар																			
УБЕГ-ын Үл хөдлөх хөрөнгийн сан	6-7-р сар																			
УБЕГ-ын Хуулийн этгээдийн сан, Бизнес регистрийн сан	6-7-р сар																			

Хяналт үнэлгээ

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Тамгын газартай хамтран баг, хорооны ХАӨМС-д хяналт, үнэлгээ хийсэн талаарх танилцуулга бичиж тооллогын хороонд танилцуулах	4-8-р сар	■	■	■	■	■															
Гарсан асуудлуудыг шийдвэрлэх	8-9-р сар						■	■													
Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны ХАӨМС-д хяналт, үнэлгээ хийх	9-12-р сар							■	■	■	■										
Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны ХАӨМС-д хяналт, үнэлгээ хийсэн талаарх танилцуулга бичиж тооллогын хороонд танилцуулах	11-12-р сар									■	■										

3. Завсрын тооллогын туршилт, үр дүнгийн хүснэгтийн боловсруулалт

Завсрын тооллогын үр дүнгийн хүснэгт, холбогдох материалыг судалж, боловсруулах	4-р сар	■																			
Завсрын тооллогын үр дүнгийн хүснэгтийг ХАӨМС болон бусад сангаас уншуулж туршилт хийх	6-р сар			■																	
Завсрын тооллогын туршилтаар өрхийн байршлын цэгийг тогтоох ажлыг турших, үр дүнг гаргах, тайлагнах	6-р сар			■																	
Завсрын тооллогын туршилтыг зохион байгуулж явуулсан тухай болон өрхийн байршлын цэгийг тогтоох ажлын тайлан боловсруулах	7-р сар				■																
Завсрын тооллогын туршилтаар гарсан асуудлыг судалж, шийдвэрлүүлэх	7-8-р сар				■	■															

4. Сурталчилгаа

ХАӨМС-гийн бүртгэл хийгдэж байгаа талаар болон мэдээллээ баяжуулах, бүртгэлийн ач холбогдолыг таниулах сурталчилгааг нийлүүлэх- Телевизийн шторк- Сурталчилгааны самбар- Телевизид ярилцлага өгөх	6-7-р сар			■	■																
ХАӨМС-гийн мэдээллийг баяжуулах, бүртгэлийн ач холбогдолыг таниулах "Нээлттэй хаалганы өдөрлөг"-ийг баг, хороонд нэгдсэн журмаар зохион байгуулах	8-12-р сар			■	■																

7.Завсрын тооллогын бэлтгэлийг орон нутагт хянах, шалгах, зөвлөх

Байшингийн дээвэр, байрны орц, хонгил, дулааны шугам сүлжээний суваг, ой мод, уул хад, агуйд амьдардаг болон албан бус аргаар ашигт малтмал олборлодог хүмүүсийг бүртгэлд бүрэн хамруулах бэлтгэл ажлыг зохион байгуулах	9-11-р сар																		
Газрын зураглал																			
Газарзүйн мэдээллийн системийг сайжруулах	4-9-р сар																		
Хүн ам, орон сууцны 2010 оны ээлжит тооллогоос хойш багийн өөрчлөлт гарсан сумд зургийг хэвлэн хүргүүлж багийн хил, заагийг тогтоож, зураглалыг гаргаж баталгаажуулах	9-11-р сар																		
Харьяа нутаг дэвсгэрийн гудамж, талбайн нэр, байр, орон сууцны хаягжилт, дугаарыг цэгцлэх ажлыг зохион байгуулах	9-11-р сар																		
Малчдын өрхийн цэгийг багийн зурагт тэмдэглүүлэх	12-р сар																		